



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2015 оны 03 сарын 12 өдөр

Дугаар A/182

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн Үйлдвэрлэл, технологийн паркийг хөгжүүлэх хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

2. Нийслэлийн Үйлдвэрлэл, технологийн паркийг хөгжүүлэх хөтөлбөрийг боловсруулан Нийслэлийн Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хуралд өргөн барих бэлтгэл ажлыг 2015 оны 2 дугаар улиралд багтаан хангахыг ажлын хэсэг /Т.Бат-Эрдэнэ/-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ



Э.БАТ-ҮҮЛ



Нийслэлийн Засаг даргын 2015 оны
05 сарын 12-ны өдрийн
А.Н.Б.З.Г.Д. захиралын хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:	Т.Бат-Эрдэнэ	Нийслэлийн Засаг даргын Экологи, ногоон хөгжлийн асуудал хариуцсан орлогч
Гишүүд:	С.Баярбаатар	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Стратегийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга
	Г.Пүрэвсүрэн	Нийслэлийн Үйлдвэр, хөдөө аж ахуйн газрын дарга
	Э.Тэмүүлин	Нийслэлийн Эдийн засгийн хөгжлийн газрын дарга
	Б.Энхбаяр	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн дарга
	Т.Ганзориг	Нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газрын Төлөвлөлт судалгааны хэлтсийн дарга
	Б.Батгэрэл	Нийслэлийн Татварын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн
	Ё.Отгонжаргал	Нийслэлийн Мэргэжлийн Хяналтын газрын Захиргаа эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн
	С.Гончигжав	Эмээлтийн Хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл технологийн парк ОНӨТҮГазрын дарга
	Н.Баяраа	Налайхын Барилгын материалын үйлдвэрлэл технологийн парк ОНӨТҮГазрын дарга
	С.Төгс	"Мэргэшсэн инженерүүдийн нийгэмлэг" ТББ-ийн тэргүүн /зөвшилцсөнөөр/
	→ Д.Бямбасайхан	Хог хаягдлыг дахин боловсруулах үндэсний холбооны тэргүүн /зөвшилцсөнөөр/
	О.Лхагвадорж	Барилгын материал үйлдвэрлэгчдийн холбооны гүйцэтгэх захирал /зөвшилцсөнөөр/
	Т.Баярсайхан	Арьс, ширний үйлдвэрлэлийн холбооны гүйцэтгэх захирал /зөвшилцсөнөөр/
	Д.Алтанцэцэг	Ноос, ноолуурын холбооны гүйцэтгэх захирал /зөвшилцсөнөөр/
	Ч.Эрдэнэбат	Ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбооны гүйцэтгэх захирал /зөвшилцсөнөөр/
Нарийн бичиг:	Т.Цэрэндэжид	Нийслэлийн Үйлдвэр, хөдөө аж ахуйн газрын Үйлдвэрлэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн